



GOLOMT BANK

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Голомт банк Монгол улсын МУТСТ тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллага (UN), Европын Холбоо (EU), АНУ-ын Сангийн Яамны дэргэдэх Гадаадын Хөрөнгийн Хяналтын Алба зэрэг байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалтыг тухай бүр шинэчилж, үйл ажиллагаандаа ашиглана.

Голомт банкны Комплаенсийн бодлогод банкны бүх салбар, нэгжүүд хэрэгжүүлэх стандартуудыг тодорхойлон оруулсан. Үүнд:

- Банк нь харилцагч болон гүйлгээг Нэгдсэн Үндэстний Байгууллага (UN), Европын Холбоо (EU), АНУ-ын Сангийн Яамны дэргэдэх Гадаадын Хөрөнгийн Хяналтын Алба зэрэг байгууллагаас гаргасан хориг арга хэмжээний жагсаалттай тулган шалгана.
 - Шинээр харилцагчаар бүртгэх үед;
 - Харилцагч мэдээллээ шинэчлэх үед;
 - Гүйлгээ хийх үед;
 - Шинээр корреспондент банкны харилцаа үүсгэх үед;
- Дараах харилцагч болон бизнесийн үйл ажиллагаа, гүйлгээг хориглоно.
 - Шууд болон шууд бусаар хориг арга хэмжээний хуулийг зөрчсөн;
 - Нэгдсэн Үндэстний Байгууллага (UN), Европын Холбоо (EU), АНУ-ын Сангийн Яамны дэргэдэх Гадаадын Хөрөнгийн Хяналтын Алба зэрэг байгууллагаас гаргасан хориг жагсаалтанд орсон хувь хүн, хуулийн этгээдтэй таарсан;
 - Харилцагчийн оршин сууж байгаа эсвэл үйл ажиллагаа явуулж байгаа улс нь хориг жагсаалтанд орсон;
 - Хориг арга хэмжээтэй холбоотой хуулийг хэрэгжүүлээгүй эсвэл зөрчсөн;
- Голомт банк хориг арга хэмжээтэй холбоотой хууль, зохицуулалтын дагуу эрсдэл өндөртэй гүйлгээг зогсоох, буцаах үүрэгтэй.

Голомт банк хориг арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай нэмэлт мэдээллийг харилцагчаас гаргуулан авдаг.

Н.Мөнхжаргал,
Комплаенсийн хэлтэс

ГОЛОМТ БАНК

2024 Он 05 сар 15 өдөр:

